



**ИНД-173**

Иргэний нисэхийн багц дүрэм

**Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллага  
- Гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаа**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## Гарчиг

А Бүлэг — Ерөнхий Зүйл.....	6
173.1 Зорилго.....	6
173.3 (Нөөц) .....	6
173.5 Гэрчилгээний шаардлага.....	6
173.7 Гэрчилгээ эзэмших хүсэлт.....	6
173.9 Гэрчилгээ олгох.....	6
173.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	7
173.13 Гэрчилгээний хугацаа.....	7
173.15 Гэрчилгээ сунгах.....	7
В Бүлэг — Гэрчилгээжүүлэлтийн шаардлага.....	7
173.51 Боловсон хүчний шаардлага.....	7
173.53 Нөөцийн шаардлага.....	8
173.55 Хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт.....	9
173.57 Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх ажилтны эрх.....	11
173.59 Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлт.....	11
173.61 Хэрэглэлийн нислэгийн журмыг зарлах.....	12
173.63 Хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт.....	13
173.65 Хэвлэгдсэн хэрэглэлийн нислэгийн журамд илэрсэн алдаа.....	13
173.67 Бүртгэл хөтлөлт.....	14
173.69 Аюулгүй ажиллагааны удирдлага.....	14
173.71 Байгууллагын Ерөнхий заавар.....	15
С Бүлэг — Үйл ажиллагааны шаардлага.....	16
173.101 Байнгын хэрэгжүүлэлт.....	16
173.103 Гэрчилгээ эзэмшигч байгууллагын өөрчлөлт.....	17
173.105 Нислэгийн журамд засвар өөрчлөлт оруулахыг зогсоох.....	18
D Бүлэг — Зохиолтын шалгуур—хэрэглэлийн нислэгийн журам.....	18
173.201 Зохиолт.....	18
E Бүлэг — Шилжилтийн зохицуулалт.....	19
173.301 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт.....	19
173.303 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон	

хүсэлт гаргагчийн шилжилтийн үеийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо.....	20
Хавсралт А – Удирдах ажилтны мэргэшил болон ажлын туршлага.....	23
А.1 Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх удирдах ажилтан.....	23
А.2 Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцах удирдах ажилтан.....	23

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

Дүрэм 173 нь дараах үйл ажиллагаанд хамааралтай журмыг тогтооно-

- хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт болон засвар өөрчлөлтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааг зохицуулах дүрмүүд; болон
- хэрэглэлийн нислэгийн журмуудыг зохиох техникийн стандартууд.

Энэхүү Дүрэм нь агаарын хөлгийн үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт эсхүл хөдөлгүүр татгалзсан онцгой нөхцөл байдлын үеийн замуудыг зохиоход ашиглагдахгүй

Дүрэм 173 нь Монгол Улсын Нислэгийн Мэдээллийн Район (НМР)-д Хэрэглэлийн Нислэгийн Дүрэм (ХНД)-ийн дагуу нислэг үйлдэж буй агаарын хөлөгт ашиглах хэрэглэлийн нислэгийн журмуудыг зохиох, засвар өөрчлөлт оруулах болон зарлах /түгээх ажиллагааг Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ОУИНБ)-ын хэрэглэлийн нислэгийн журмын стандартууд болон практик зөвлөмжүүдэд нийцүүлэх, эсхүл илүү өндөр түвшинд боловсруулахыг бататгах зорилготой.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-173-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-173, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) вэб сайтаас татаж авах боломжтой.

## Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ-Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 05 сарын 06-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол улсын иргэний нисэхийн багц дүрмийн Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-173 нь анх 2002 оны 12 сарын 20-нд хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах нэмэлт, өөрчлөлтийг багтаасан:

<b>Нэмэлт, өөрчлөлт</b>	<b>Хүчин төгөлдөр болсон огноо</b>
-------------------------	------------------------------------

Нэмэлт, өөрчлөлт 1	2010 оны 03 дугаар сарын 25
--------------------	-----------------------------

Нэмэлт, өөрчлөлт 1	2016 оны 03 дугаар сарын 01
--------------------	-----------------------------

ИНД-173-ийн Өөрчлөлт 2-ийг Шинэ Зеландын Part 173-ийн 2010 оны 03-р сарын 25-ны Өөрчлөлт 1-г үндэслэн боловсруулсан болно.

**Тэмдэглэл:** ИНД-173-г англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

## **А Бүлэг — Ерөнхий зүйл**

### **173.1 Зорилго**

(a) Энэ Дүрэм нь дараах үйл ажиллагааны журмыг тогтооно—

- (1) хэрэглэлийн нислэгийн журам зохиох болон засвар өөрчлөлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг гэрчилгээжүүлэх болон үйл ажиллагааг зохицуулах дүрмүүд;
- (2) хэрэглэлийн нислэгийн журмуудыг зохиох техникийн стандартууд.

(b) Энэхүү Дүрэм нь агаарын хөлгийн үйл ажиллагааны үзүүлэлтийн хязгаарлалт эсхүл хөдөлгүүр татгалзсан онцгой нөхцөл байдлын үеийн замуудыг зохиоход ашиглагдахгүй.

### **173.3 (Нөөц)**

### **173.5 Гэрчилгээний шаардлага**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ дүрмийн дагуу олгогдсон хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээгүй аливаа этгээд нь дараах бүсэд хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээг үзүүлэхгүй—

- (1) Монгол Улсын НМР; эсхүл
- (2) Хамааралгүй;

(b) Хамааралгүй

### **173.7 Гэрчилгээ эзэмших хүсэлт**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24173/01 маягтыг бөглөж дараах зүйлсийг хавсарган Даргад ирүүлнэ—

- (1) 173.71-д заасан үйл ажиллагааны заавар;
- (2) Хамааралгүй

### **173.9 Гэрчилгээ олгох**

Хүсэлт гаргагчийг дараах шаардлагуудыг хангасан гэж Дарга үзвэл хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээг хууль болон дүрэмд заасны дагуу олгоно—

- (1) хүсэлт гаргагч нь В Бүлэгт заасан шаардлагуудыг хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч болон 173.51(а)-д шаардсан удирдах ажилтнууд нь тохирсон чадвартай байх;
- (3) гэрчилгээг олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.

### **173.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ нь—

- (1) гэрчилгээ эзэмшигчид дараах эрхүүдийг олгоно—
  - (i) хэрэглэлийн нислэгийн журмыг зохиох, нислэгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон хэрэглэлийн нислэгийн журамд засвар өөрчлөлт оруулах;
  - (ii) гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээжүүлсэн, хэвлэх ба агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашиглах хэрэглэлийн нислэгийн журамтай холбоотой нисэхийн өгөгдлийг агуулсан нисэхийн мэдээллийг ИНД 95-ийн шаардлагуудын дагуу гаргах;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн зохиох, нислэгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт оруулах хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдийг гэрчилгээнд заасан байна.

### **173.13 Гэрчилгээний хугацаа**

- (a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаатай олгоно, эсхүл сунгана.
- (b) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ нь хүчинтэй хугацаа дуусах эсхүл түдгэлзүүлэх эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.

### **173.15 Гэрчилгээ сунгах**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлтийг САА24173/01 маягтын дагуу гаргаж, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлнэ.

## **В Бүлэг — Гэрчилгээжүүлэлтийн шаардлага**

### **173.51 Боловсон хүчний шаардлага**

- (a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах боловсон хүчинг гэрээгээр эсхүл бусад хэлбэрээр ажиллуулна—
  - (1) удирдах албан тушаалтан нь—
    - (i) хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ нь байгууллагын хүрээнд энэ дүрэмд заасан стандарт, шаардлагуудын дагуу явагдаж, санхүүжиж байгааг бататгах эрхтэй байна;
    - (ii) байгууллага нь энэ дүрмийн шаардлагуудад нийцэж байгааг бататгах үүрэгтэй байна;
  - (2) удирдах албан тушаалтны өмнө ахлах ажилтан эсхүл ажилтнууд нь дараах хариуцлагуудыг хүлээнэ —

- (iii) байгууллага нь Үйл ажиллагааны зааврыг дагаж мөрдөж/хэрэгжүүлж байгааг бататгах;
  - (iv) байгууллагаас нийлүүлж байгаа болон ИНД-95-ын дагуу НМЭ-д оруулан хэвлэх, ашиглахад бэлэн болсон хэрэглэлийн нислэгийн журам бүрийн гэрчилгээжүүлэлтийг;
  - (v) 173.69-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог;
- (3) хүсэлт гаргагч байгууллагаас нийлүүлэх хэрэглэлийн нислэгийн журмуудыг төлөвлөх, зохиох, шалган батлах болон засвар өөрчлөлт оруулах хангалттай тооны ажилтнууд.
- (b) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтнуудын ур чадварыг үнэлэх, сургах болон ур чадварыг хадгалах журмыг боловсруулсан байна —
- (1) хэрэглэлийн нислэгийн журмыг төлөвлөх, зохиох, шалган батлах болон засвар өөрчлөлтөд оролцох ажилтнууд;
  - (2) хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх бүхий ахлах ажилтнууд.
- (c) Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлтийг хариуцсан ахлах ажилтан эсхүл ажилтнуудад 173.57-ийн дагуу нислэгийн журам гэрчилгээжүүлэх эрх олгогдсон байна.
- (d) Энэ зүйлийн (a)(2)-т заасан ахлах ажилтнуудад тавигдах мэргэшлийн болон дадлага туршлагын шаардлагыг Хавсралт А-д тусгав.

### **173.53 Нөөцийн шаардлага**

- (a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах нөөцөөр хангагдсан байна—
- (1) хүсэлт гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдийг зохиох, зохиолтыг шалган баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлт зэрэгт шаардлагатай төхөөрөмж;
  - (2) хүсэлт гаргагч байгууллагын гэрчилгээжүүлсэн болон засвар өөрчлөлт оруулсан хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт, зохиолтыг шалган баталгаажуулах, нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлтөд ашигласан нисэхийн өгөгдөл, газрын хаялбарын өгөгдөл, саадын өгөгдөл гэх мэт холбогдох хүчин төгөлдөр өгөгдлүүдийг ашиглах боломжтой байх;
  - (3) өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны зааварт тусгагдсан хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдийн зохиолт, зохиолтыг шалган баталгаажуулах, гэрчилгээжүүлэх, нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлтөнд хэрэгтэй техникийн стандарт, зөвлөмж, зааврууд болон бусад баримт бичгүүдээс бүрдсэн холбогдох баримт бичгүүдийн хувь ашиглахад бэлэн байх.
- (b) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах зүйлсийг бататгах журмыг боловсруулсан байна—



- (1) хүсэлт гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдэд шаардлагатай, (а)(2)-т заасан өгөгдлүүдийг ажилтнууд нь ашиглах боломжтой байх;
  - (2) (а)(2)-т заасан өгөгдөл нь хүчин төгөлдөр, мөшгөх боломжтой болон хүсэлт гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт, зохиолтыг шалган баталгаажуулах, нислэгээр баталгаажуулах болон засвар өөрчлөлтөд шаардлагатай нарийвчлалын түвшинд нийцсэн байх.
- (с) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах зүйлсийг бататгах зорилгоор (а)(3)-ын шаардсан бүх баримт бичгийн хяналтын журмыг боловсруулсан байна—
- (1) баримт бичгийг хэвлэж, ашиглаж эхлэхээс өмнө холбогдох ажилтнаар хянуулж, зөвшөөрүүлсэн байх;
  - (2) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг шаардлагатай ажлын байр бүрт, ажилтнууд авч ашиглахад боломжтой байх;
  - (3) хүчингүй болсон баримт бичгийг тараалт болон ашиглалтын аль ч үе шатнаас шууд хасах;
  - (4) баримт бичгийн өөрчлөлтийг хэвлэж, ашиглаж эхлэхээс өмнө холбогдох ажилтнаар хянуулж, зөвшөөрүүлсэн байх;
  - (5) баримт бичгийн зүйл заалт бүрийн хүчинтэй хувилбар нь хүчингүй материал ашиглахаас сэргийлж ялгах боломжтой байх.

### **173.55 Хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт**

- (а) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гэрчилгээгээр олгогдох эрхийн хүрээнд 173.59-ын дагуу гэрчилгээжүүлсэн хэрэглэлийн нислэгийн журам бүр нь дараах нөхцлүүдийг хангасан гэдгийг бататгах журмыг боловсруулсан байна—
- (1) D Бүлэгт заасан холбогдох стандарт болон шаардлагуудыг хангасан эсэхийг бататгадаг аргыг ашиглан журмыг зохиосон эсхүл өөрчлөлт оруулсан байх;
  - (2) гэрчилгээжүүлэлтээс өмнө, зохиолтод шууд оролцоогүй, мэргэшсэн ажилтан бие даан шалган баталгаажуулсан байх;
  - (3) (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах зүйлсийг бататгахын тулд (с)-д шаардсан журмын дагуу нислэгээр баталгаажуулсан байх—
    - (i) хэрэглэлийн нислэгийн журмыг ашиглахад тухайн ангилалын агаарын хөлөг хэвийн аюулгүй ажиллагааны нөхцөл болон нисэгчийн ажлын ачааллын хүрээнд маневр хийх боломжтой байх;
    - (ii) хэрэглэлийн нислэгийн журмаар нисэж буй агаарын хөлөг нь саадаас чөлөөлөгдсөнийг бататгахын тулд тухайн журам нь ОУИНБ-ын болон бусад агаарын хөлгийн үйл ажиллагааны стандартуудын дагуу зүг чиг болон зайн мэдээлэл, нарийвчлалтай ойртолтын хувьд босоо чиглэлийн мэдээллийг агуулсан байх;

- (iii) хэрэглэлийн нислэгийн журам нь аливаа радио давтамжийн тасалдлын нөлөөнд автахгүй байх;
  - (iv) Ил харааны баримжааны систем болон ХБЗ-ны дохио тэмдэгүүд нь тухайн хэрэглэлийн нислэгийн журамд ашиглахад тохиромжтой байх аливаа гэрэлтүүлэг, өндөрт байрласан лазер самбарууд, эсхүл анхаарал сарниулах бусад зүйлстэй андуурагдахгүй байх.
- (b) Хүчин төгөлдөр саадын өгөгдөл нь хэрэглэлийн нислэгийн журам зохиолтын шаардлагуудыг хангаж буй тохиолдолд дараах хэрэглэлийн нислэгийн журмуудыг нислэгээр баталгаажуулах шаардлагагүй:
- (1) доор дурьдсанаас бусад тохиолдолд маршрутын эсхүл хэрэглэлээр нисэн ирэх журам—
    - (i) журамд ашиглагдах навигацийн тоног төхөөрөмжийн бүрхэлтэнд эргэлзээ байгаа;
    - (ii) журам нь зориулагдсан агаарын хөлгийн ангиллынхаа нисэх чадвар болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг хязгаарлаж байгаа:
  - (2) хэрэглэлээр нисэн гарах журам нь зориулагдсан ангиллынхаа агаарын хөлгийн нисэх чадвар болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг хязгаарлаагүй тохиолдолд:
  - (3) өмнө нь нислэгээр баталгаажуулсан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын өөрчлөлт, хэрэв—
    - (i) зохиолтод орох өөрчлөлтийг журам зохиолтын явцад шалган баталгаажуулах боломжтой бол;
    - (ii) төлөвлөж буй өөрчлөлтийн аюулгүй ажиллагааны үнэлгээгээр тухайн өөрчлөлт нь журмын аюулгүй ажиллагаанд аливаа нэмэлт эрсдлүүд учруулахгүй болохыг баталсан бол.
- (c) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь (a)(3)-аар шаардсан нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах журмыг боловсруулсан байна.
- (d) (c)-д заасан нислэгээр баталгаажуулах журамд доорх шаардлагуудыг хангасан тоног төхөөрөмжийг ашиглах тухай заасан байна—
- (1) баталгаажуулалтыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай стандартуудад нийцсэн нарийвчлалтай байх;
  - (2) нэмэлт програм хангамж, системийн програм болон хөндлөнгийн салхины хэмжилтийн алдаа зэрэг хэмжилтийн нарийвчлалын алдааг урьдчилан тогтоосон байх;
  - (3) нислэгээр баталгаажуулалт хийж буй агаарын хөлгийн ниссэн бодит замыг бичдэг байх,
  - (4) хэрэглэлийн нислэгийн журмын цогц байдлыг шалгаж батлах чадавхийг нь хангахын тулд системийг ашиглаж эхлэхээс өмнө болон үйлдвэрлэгчээс зөвлөсөн хугацаанд үзлэг, тохируулга хийдэг байх,

(5) нислэгээр баталгаажуулах системийн журам болон шалгууруудынх нь дагуу тухайн системийг эрх бүхий ажилтан ажиллуудаг байх.

(e) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь (b) заалтыг зохицуулсан журмыг боловсруулсан байна.

(f) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журмыг зохиох, засвар өөрчлөлт оруулах болон өгөгдлийг дамжуулах үйл явцуудад дараах нөхцлүүд хангагдана гэдгийг бататгах журмыг боловсруулсан байна—

(1) холбогдох нисэхийн өгөгдөл болон нисэхийн мэдээллүүд нь RTCA Inc. дугаар RTCA/DO-201A Нислэгийн Мэдээллийн Стандартууд баримт бичигт заасан стандартуудыг хангасан;

(2) нисэхийн өгөгдлийн ашиглалт эсхүл боловсруулалт нь RTCA Inc. дугаар RTCA/DO-200A Нисэхийн Өгөгдөл Боловсруулах Стандартууд баримт бичигт заасан стандартуудыг хангасан;

(3) гэрчилгээ эзэмшигч байгууллага дотор эсхүл гадны байгууллагуудад болон байгууллагуудаас нисэхийн мэдээлэл дамжуулах аливаа үйл явц нь Нисэхийн Мэдээлэл Дамжуулах Модуль (AIXM-5)-д заасан стандартуудыг хангасан.

(g) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь (f)-д заасан стандартуудтай тэнцэх бусад стандартуудыг ашиглаж болно.

### **173.57 Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх ажилтны эрх**

(a) Энэхүү зүйлийн (b),(c) болон (d)-д заасны дагуу хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн хэрэглэлийн нислэгийн журам D Бүлэгт заасан холбогдох бүх стандарт болон шаардлагуудад нийцэж, тэдгээрийн дагуу зохиогдсон болохыг гэрчилгээжүүлэх ахлах ажилтан эсхүл ажилтнуудад эрх олгох тухай журамтай байна.

(b) Хавсралт А.1.-д заасан сургалт болон дадлага, туршлагын шаардлагуудыг хангаагүй ажилтанд гэрчилгээжүүлэх эрх олгохгүй.

(c) Ажилтанд эрхийг бичгээр олгох бөгөөд уг баримт бичигт тухайн ажилтан гэрчилгээжүүлэх эрхтэй хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдийг заасан байна.

(d) Ажилтанд олгосон гэрчилгээжүүлэх эрхийн баримт бичигт заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрөл нь хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээнд заасан хэрэглэлийн нислэгийн журмуудын төрлүүдтэй нийцэж байх ёстой.

### **173.59 Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлт**

(а) Энэ зүйлийн (b) болон (c)-д заасны дагуу хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь зохиохоор санал болгож, төлөвлөж байгаа, үйл ажиллагаанд ашиглах болон Монгол Улсын Нисэхийн Мэдээллийн Эмхэтгэлд хэвлэхэд бэлэн болгох хэрэглэлийн нислэгийн журам бүрийг гэрчилгээжүүлэх журмыг боловсруулсан байна.

(b) Энэ зүйлийн(а)-д шаардсан журам нь дараах зүйлсийг агуулсан байна—

- (1) хэрэглэлийн нислэгийн журам нь энэ дүрэмд заасан холбогдох стандарт болон шаардлагуудад нийцэж буйг бататгахын тулд хэрэглэлийн нислэгийн журмын тодорхой төрлийг гэрчилгээжүүлэх эрх бүхий ахлах ажилтны шалгах зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) хэрэглэлийн нислэгийн журмыг Монгол Улсын Агаарын Навигацийн Бүртгэлд оруулахад 173.61 (c)-д тусгагдсан мэдээллээр Даргыг хангах тухай.

(c) 173.57-д заасны дагуу хэрэглэлийн нислэгийн журам гэрчилгээжүүлэх эрх олгогдсон ажилтан нь өөрийн зохиосон хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэхгүй.

### **173.61 Хэрэглэлийн нислэгийн журмыг зарлах**

(а) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-95.51-ийн дагуу дараах зүйлүүдийг бататгах журамтай байна—

- (1) энэ зүйлийн (c)-д шаардсан мэдээллээр Даргыг хангасан байх;
- (2) аливаа хэрэглэлийн нислэгийн журмыг Агаарын Навигацийн Бүртгэлд ИНД-95.55-ын дагуу оруулсан эсэхийг хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчид Дарга мэдэгдээгүй тохиолдолд тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг хэвлэхгүй эсхүл ашиглалтанд зориулан гаргахгүй байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах зүйлсийг агуулсан байна—

- (1) хэрэглэлийн нислэгийн журмыг НМЭ-д хэвлэх асуудлыг нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагатай хэрхэн зохицуулсан талаар дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) энэ зүйлийн (а)-ын дагуу хэвлэгдсэн хэрэглэлийн нислэгийн журмын анхны хэвлэлт эсхүл түүнд орох аливаа өөрчлөлт нь НМЭ-д үнэн зөв хэвлэгдсэнийг шалгах аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

(c) Агаарын Навигацийн Бүртгэлд оруулж буй хэрэглэлийн нислэгийн журам бүрийн талаар дараах мэдээллийг Даргад хүргүүлэх шаардлагатай:

- (1) тухайн хэрэглэлийн нислэгийн журмыг бусад журмуудаас ялгаж таних, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нэр эсхүл бусад төрлийн таних тэмдэг;
- (2) хэрэглэлийн нислэгийн журмыг тодорхойлсон болон дүрсэлсэн, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн өгөгдөл;
- (3) хэрэглэлийн нислэгийн журмыг хүчин төгөлдөр болгохоор төлөвлөсөн огноо:

- (4) ИНД-173.59(b)(1)-д заасан, тухайн хэрэглэлийн нислэгийн журам энэ дүрэмд заасан стандарт болон шаардлагуудад нийцэж буйг нотолж удирдах ажилтан гарын үсэг зурсан мэдэгдэл:
- (5) хэрэглэлийн нислэгийн журмын засвар, өөрчлөлтүүдийг зохих хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ эрхэлсэн байгууллага, ИНД-173.63-д шаардсан журмын дагуу оруулахыг нотолж байгууллагын удирдах ажилтан гарын үсэг зурсан мэдэгдэл.

(d) Энэ зүйлийн (c)(5)-ын зорилгын үүднээс, хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ эрхэлсэн байгууллага нь ИНД-173-ын дагуу гэрчилгээжсэн бөгөөд энэхүү гэрчилгээний хүрээнд хэрэглэлийн нислэгийн журмын тодорхой төрлийг зохиох, нислэгээр баталгаажуулах, гэрчилгээжүүлэх болон засвар өөрчлөлт оруулах эрх бүхий байгууллага байна.

### **173.63 Хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлт**

(a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журам бүрт 173.61(c)(5)-д заасны дагуу гэрчилгээгээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд энэхүү Дүрмийн шаардлагуудад нийцүүлэн засвар өөрчлөлт оруулах журмыг боловсруулсан байна.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дүн шинжилгээ хийгдэх, хэрэв шаардлагатай бол нислэгээр баталгаажуулах хэрэглэлийн нислэгийн журам бүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна—

- (1) хэрэглэлийн нислэгийн журам нь энэхүү дүрмийн стандарт болон шаардлагуудад нийцэж байгаа эсэхийг тодорхой хугацаа тогтмол бататгах;
- (2) 173.53(a)(2)-т заасан аль нэг өгөгдөлд, хэрэглэлийн нислэгийн журмын цогц байдалд нөлөөлж болзошгүй өөрчлөлт орсон тохиолдолд.

(c) Энэ зүйлийн (a)-д шаардсан журамд хэрэглэлийн нислэгийн журам бүрийн ээлжит дүн шинжилгээ хоорондын хугацааг тогтоох эсхүл өөрчлөх үндэслэл болон шалгууруудыг багтааж, баримтжуулсан байна.

### **173.65 Хэвлэгдсэн хэрэглэлийн нислэгийн журамд илэрсэн алдаа**

(a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд гэрчилгээжүүлсэн эсхүл засвар өөрчлөлт оруулсан хэрэглэлийн нислэгийн журамд гарсан энэ дүрмийн стандарт ба шаардлагуудтай нийцээгүй аливаа алдаа болон үл тохирол, эсхүл болзошгүй үл тохирлыг ИНД-12-ын дагуу бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон мэдээлэх журмыг боловсруулсан байна.

(b) Энэ зүйлийн(a)-д шаардсан журмаар дараах шаардлагуудыг тавина—

- (1) хэрэв (a)-д дурдсан алдаа эсхүл үл тохирол нь агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа эсхүл нөлөөлж болзошгүй тохиолдолд ашиглалтаас шууд гаргасан байх;

- (2) 173.57-д заасны дагуу эрх олгогдсон ахлах ажилтан нь алдаа эсхүл үл тохирлыг залруулж, гэрчилгээжүүлсэн байх;
- (3) тухайн алдаа эсхүл үл тохирлын үйл ажиллагаан дахь ач холбогдолоор энэ зүйлийн (b)(2)-т дурдсан залруулгыг ойлгомжтой тодорхойлж, зарласан байна;
- (4) алдаа эсхүл үл тохирлын эх сурвалжийг тогтоосон байх, ба—
  - (i) хэрэв боломжтой бол дахин давтагдахаас урьдчилан сэргийлж устгасан байх;
  - (ii) алдаа эсхүл үл тохирлын эх сурвалж нь бусад ямар нэгэн хэрэглэлийн нислэгийн журмын цогц байдалд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авсан байх;
- (5) (a)-д дурдсан алдаа эсхүл үл тохиролтой холбоотой зарлагдсан мэдээллүүдийн зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдсэн байна.

#### **173.67 Бүртгэл хөтлөлт**

- (a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт, гэрчилгээжүүлэлт болон засвар өөрчлөлттэй холбоотойгоор хүсэлт гаргагч байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бүртгэл хөтлөлтийн журам боловсруулсан байна.
- (b) Энэхүү зүйлийн (a)-д заасан бүртгэл хөтлөлтөд бүртгэлийн нэр, цуглуулалт, индексжүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглах боломж, засвар өөрчлөлт болон устгал орно.
- (c) Энэхүү зүйлийн (a)-д заасан журам нь 173.59-ын дагуу гэрчилгээжүүлсэн болон 173.63-ын дагуу засвар өөрчлөлт оруулсан хэрэглэлийн нислэгийн журам бүрт дараах зүйлсийг бүртгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна—
  - (1) 173.61(c)-д шаардсан хэрэглэлийн нислэгийн журамд шаардлагатай мэдээллүүд;
  - (2) 173.55-д заасны дагуу гүйцэтгэсэн хэрэглэлийн нислэгийн журмын зохиолтын баталгаажуулалт, өөрчлөлт, шалган баталгаажуулалт, баталгаажуулаагүй тохиолдолд түүний үндэслэл болон гэрчилгээжүүлэлт зэрэг үйл ажиллагаануудын тодорхой мэдээллүүд;
  - (3) зарласан болон шалгасан үйл явцын тодорхой мэдээллүүд; and
  - (4) хэрэглэлийн нислэгийн журамд гарсан алдаа болон үл тохиролтой холбоотойгоор, 173.65-ын хүрээнд авсан аливаа арга хэмжээний тодорхой мэдээллүүд;
  - (5) 173.63-д шаардсан журмын дагуу гүйцэтгэсэн засвар өөрчлөлтийн дүн шинжилгээ болон нислэгээр баталгаажуулсан мэдээллүүд.
- (d) Энэхүү зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах зүйлсийг мөн агуулсан байна—

- (1) доор дурдсан ажилтнуудын мэргэшил, дадлага туршлага, сургалт, үнэлгээ болон шаардлагатай бол олгогдсон эрхийн талаар мэдээллүүдийг багтаасан бүртгэл—
  - (i) 173.51(a)(2)-т заасан бүх ахлах ажилтнууд;
  - (ii) 173.51(a)(3)-т заасан бүх ажилтнууд;
- (2) [хүчингүй]
- (3) (c) болон (d)-д заасан бүртгэлүүд нь уншихад ойлгомжтой, үнэн зөв, тогтмол болон ойлгоход хялбар форматтай ашиглахад бэлэн байх;
- (4) (c)-д заасан бүртгэлийг холбогдох хэрэглэлийн нислэгийн журам нь хэрэглээнээс гарснаас хойш 5 жилээс доошгүй хугацаанд хадгалах.

### **173.69 Аюулгүй ажиллагааны удирдлага**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-т шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон цаашид хадгалах ёстой.

### **173.71 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны заавар**

- (a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах зүйлсийг тусгасан үйл ажиллагааны зааврыг даргад хүргүүлнэ—
  - (1) үйл ажиллагааны заавар болон бусад дагалдах баримт бичгүүд нь дараах шаардлагуудыг хангасан болохыг нотолж хүсэлт гаргагч байгууллагын өмнөөс гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл—
    - (i) байгууллагын тодорхойлолт болон байгууллагын энэхүү Дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг бататгах арга хэлбэрүүд болон арга барилын илэрхийлэл;
    - (ii) хүсэлт гаргагч байгууллагын ажилтнууд үйл ажиллагааны заавартай байнга нийцэн ажилахыг;
  - (1A) 173.69-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбоотойгоор,—
    - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичгүүд;
    - (ii) хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээний хугацааг сунгахаас бусад хүсэлт гаргагч нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарласан төлөвлөгөө;
  - (2) 173.51(a)(2)-т заасан ахлах ажилтан эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэрс;
  - (3) 173.51(a)(1) болон (2)-т заасан ахлах ажилтан эсхүл ажилтнуудын үүрэг болон хариуцлага—

- (i) байгууллагын өмнөөс Дарга эсхүл Эрх бүхий байгууллагатай шууд харилцах асуудлууд;
- (ii) аюулгүй ажиллагааны удирдлагатай холбоотой хариуцлагууд;
- (4) хэрэв (2) дахь заалтад нэгээс дээш ахлах ажилтныг заасан бол тэдгээр ажилтнуудын үүрэг хариуцлагын чиглэлийг харуулсан байгууллагын дотоод зохион байгуулалтын бүдүүвч;
- (4A) байгууллага доторх аюулгүй ажиллагаатай холбоотой үүрэг хариуцлагыг тодорхойлсон мэдээлэл;
- (5) 173.57-д шаардсаны дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх эрх олгогдсон ахлах ажилтан бүрийн нэрс;
- (6) (5)-д шаардсан ажилтан бүрт олгогдсон эрхүүдийн тухай мэдээлэл;
- (7) хүсэлт гаргагч байгууллагын зохиох, гэрчилгээжүүлэх эсхүл засвар өөрчлөлт оруулах хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүдийн жагсаалт;
- (8) 173.53(a)-д заасан шаардлагуудыг хүсэлт гаргагч хэрхэн хангах тухай доорх зүйлстэй холбоотой нарийвчилсан мэдээлэл—
  - (i) тоног төхөөрөмж;
  - (ii) холбогдох болон хүчин төгөлдөр өгөгдлийг ашиглах боломж;
  - (iii) холбогдох баримт бичгүүдийн хувиудыг ашиглах боломж;
- (9) нислэгээр баталгаажуулах шаардлагагүй хэрэглэлийн нислэгийн журамтай холбоотойгоор 173.53(b) заалтын шаардлагуудыг хүсэлт гаргагч хэрхэн хангах тухай нарийвчилсан мэдээлэл;
- (10) доор дурдсан шаардлагуудын дагуу хүсэлт гаргагчийн боловсруулсан журмууд—
  - (i) 173.51(b)-ын дагуу ажилтнуудын үнэлгээ болон ур чадварын тухай;
  - (ii) 173.53(b)(1)-ын дагуу өгөгдлийг ашиглах боломжийн тухай;
  - (iii) 173.53(b)(2)-ын дагуу өгөгдлийн нарийвчлал, хүчин төгөлдөр байдлын тухай;
  - (iv) 173.53 (c)-ын дагуу баримт бичгийн хяналтын тухай;
  - (v) 173.55(a)-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт, шалгаж батлах болон нислэгээр баталгаажуулах тухай;
  - (vi) 173.55(c)-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг нислэгээр баталгаажуулах тухай;
  - (vii) 173.55(e) -ын дагуу нислэгээр баталгаажуулах шаардлагагүй хэрэглэлийн нислэгийн журмын үндэслэлийн тухай;
  - (viii) 173.55(f) эсхүл (g)-ын дагуу стандартуудыг дагаж мөрдөх тухай;
  - (ix) 173.57-ын дагуу ахлах ажилтнуудад олгогдсон эрхийн тухай;
  - (x) 173.59-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээжүүлэлтийн тухай;



- (xi) 173.61-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмыг зарлах болон журам бүрийн талаарх нарийвчилсан мэдээллээр Даргыг хэрхэн хангах тухай;
  - (xii) 173.63-ын дагуу хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлтийн тухай;
  - (xiii) 173.65-ын дагуу хэвлэгдсэн хэрэглэлийн нислэгийн журамд илэрсэн алдааны тухай;
  - (xiv) 173.67-ын дагуу бүртгэл хөтлөлтийн тухай;
  - (xv) *[хүчингүй]*
- (11) үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөх болон түгээх тухай журмууд.
- (b) Хүсэлт гаргагчийн үйл ажиллагааны заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

## **С Бүлэг — Үйл ажиллагааны шаардлага**

### **173.101 Байнгын хэрэгжилт**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь—

- (1) 173.71-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааврын нэг ширхэг хүчин төгөлдөр, бүрэн хувийг үндсэн байгууллага дээрээ хадгална;
- (2) үйл ажиллагааны зааварт орсон журам болон стандарт бүрийг дагаж мөрдөнө;
- (3) гүйцэтгэх ажил үүрэгтэй нь холбоотой үйл ажиллагааны зааврын холбогдох хэсгийг ажлын байр бүрт бэлэн байлгах;
- (4) энэ Дүрэмд заасан, гэрчилгээжүүлэлтэд шаардлагатай В Бүлгийн шаардлагууд болон стандартуудыг байнга дагаж мөрдөх;
- (5) гэрчилгээ эзэмшигчийн шуудангийн хаяг, үйлчилгээний хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарт гарсан аливаа өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгдэнэ.

### **173.103 Гэрчилгээ эзэмшигч байгууллагын өөрчлөлт**

(a) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь—

- (1) (b)-д заасны дагуу, эзэмшигч байгууллагын үйл ажиллагааны заавар нь тус байгууллагын хамгийн сүүлийн үеийн мэдээллийг агуулах зорилгоор өөрчлөлт хийгдэж байгааг бататгах;
- (2) байгууллагын үйл ажиллагааны зааварт орсон аливаа өөрчлөлт нь энэхүү Дүрмийн холбогдох шаардлагуудтай нийцэж буйг бататгах;
- (3) байгууллагын үйл ажиллагааны зааварт орсон журмын өөрчлөлтийг мөрдөх;

- (4) гэрчилгээ эзэмшигчээс үйл ажиллагааны зааварт оруулсан аливаа өөрчлөлт бүрийг, тухайн өөрчлөлтийг мөрдөж эхлэх үед нэн даруй, Даргад хүргүүлнэ;
- (5) Даргын зүгээс нисэхийн аюулгүй ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг байгууллагын үйл ажиллагааны зааварт оруулна.
- (b) Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг оруулахаас өмнө Даргаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай:
- (1) удирдах албан тушаалтан:
  - (2) 173.71(a)(2)-т шаардсан байгууллагын үйл ажиллагааны зааварт тусгасан аливаа ахлах ажилтны нэр, эсхүл албан тушаал:
  - (3) эзэмшигчийн гэрчилгээнд заасан хэрэглэлийн нислэгийн журмын төрлүүд:
  - (4) хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны материалын өөрчлөлт бол.
- (c) (b)-д заасан аливаа өөрчлөлтийн явцад эсхүл өөрчлөлтийн дараа хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх нөхцөлүүдийг Дарга тогтоож өгч болно.
- (d) Хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээ эзэмшигч нь (c)-д заасан, Даргаас тогтоож өгсөн нөхцөлүүдийг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (e) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтүүдийн аль нэг нь хэрэглэлийн нислэгийн журмын гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгосон тохиолдолд гэрчилгээ эзэмшигч гэрчилгээгээ Даргад яаралтай илгээж өөрчлөлт оруулах зөвшөөрөл авна.

### **173.105 Хэрэглэлийн нислэгийн журамд засвар өөрчлөлт оруулахыг зогсоох**

Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь 173.63-д шаардсаны дагуу хэрэглэлийн нислэгийн журмын засвар өөрчлөлтийг зогсоохоор төлөвлөсөн тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь засвар өөрчлөлтийн үйлчилгээг зогсоохоос 90-с доошгүй хоногийн өмнө саналаа Даргад бичгээр мэдэгдэнэ.

## **D Бүлэг — Зохиолтын шалгуур—хэрэглэлийн нислэгийн журам**

### **173.201 Зохиолт**

(a) Хэрэглэлийн нислэгийн журам бүрийг энэхүү Дүрмийн шаардлагууд болон дор дурдсан баримт бичгүүдэд заасан зохиолтын үйл явц, стандарт, зааврууд болон нислэгийн өгөгдлийн чанарын шаардлагуудад нийцүүлэн зохионо:

- (1) ОУИНБ-ийн Баримт бичгүүд—
  - (i) Дос 8168, Агаарын Навигацийн Үйлчилгээний Журам - Агаарын Хөлгийн Үйл Ажиллагаа - Боть I Нислэгийн Журмууд, болон Боть II, Ил Харааны болон Хэрэглэлийн Нислэгийн Журмын Байгуулалт:

- (ii) Дос 8697, Нисэхийн Зургийн Заавар:
- (iii) Дос 9365, Дос 9365, Цаг Уурын Үйл Ажиллагааны Заавар:
- (iv) Дос 9613 Үзүүлэлтэд Тулгуурласан Навигацийн Заавар - Боть I Ухагдахуун болон Хэрэгжүүлэлтийн Гарын авлага, болон Боть II RNAV болон RNP-ийн хэрэгжүүлэлт:
- (v) Дос 9881, Электрон Газрын Гадарга, Саад болон Аэродромын Зураглалын Мэдээллийн Гарын авлага:

(2) ОУИНБ-ын Хавсралтууд—

- (i) Хавсралт 4, Нисэхийн Зураг:
- (ii) Хавсралт 6, Агаарын Хөлгийн Үйл Ажиллагаа:
- (iii) Хавсралт 11, Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээ:
- (iv) Хавсралт 14, Боть I болон Боть II Аэродром:
- (v) Хавсралт 15, Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ:

(3) Хэрэглэлийн нислэгийн журмын тодорхой төрөлд тохиромжтой бөгөөд Даргын зүгээс хүлээн зөвшөөрөхүйц бусад заавар эсхүл стандарт.

(b) Энэ зүйлийн (a)-ийн зорилгын үүднээс хэрэв зохиолтын үйл явц, стандарт, заавар эсхүл нисэхийн өгөгдлийн чанарын шаардлагуудын хооронд зөрүүтэй зүйлс гарсан тохиолдолд Даргын зүгээс хүлээн зөвшөөрсөн эсхүл тодорхойлсон зохиолтын үйл явц, стандарт эсхүл зааврыг ашиглана.

(c) Хэрэглэлийн нислэгийн журмын зохиолт нь—

- (1) холбогдох бүх нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэгчидтэй харилцан уялдаатай байх;
- (2) хэрэглэлийн нислэгийн журам зохиохоор төлөвлөсөн бүс эсхүл агаарын зайн бүсүүдийн дотор үзүүлдэг аливаа нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ болон түүнтэй холбоотой журамтай нийцсэн байх;
- (3) дараах зүйлсийг харгалзсан байна—
  - (i) Хамааралгүй
  - (ii) агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа тогтоол, дүрэм эсхүл бусад хууль эрх зүйн баримт бичгүүд;
  - (iii) хэрэглэлийн нислэгийн журам зохиох агаарын зайн ангилал болон тэдгээрийн нэршлүүд, нислэгийн журам нөлөөлж болзошгүй зэргэлдээ агаарын зай;
  - (iv) төлөвлөсөн хэрэглэлийн нислэгийн журам тухайн агаарын зайд зохиогдсон бусад хэрэглэлийн нислэгийн журмуудад үзүүлэх нөлөө.

(d) Аэродром эсхүл хэлипортын эзэмшигчийн зүгээс тухайн аэродром эсхүл хэлипортыг төлөвлөсөн хэрэглэлийн нислэгийн журмыг ашиглах ХНД-ийн нислэгүүдэд ашиглаж болохыг бичгээр зөвшөөрөөгүй тохиолдолд аэродром эсхүл хэлипортод зориулан хэрэглэлийн нислэгийн журам зохиохгүй.

(e) Доор дурдсанаас бусад тохиолдолд газар суурилсан нисэхийн тоног төхөөрөмжүүд дээр тулгуурласан эсхүл тэдгээрийг ашигласан хэрэглэлийн нислэгийн журам зохиохгүй—

- (1) нисэхийн тоног төхөөрөмжийг ИНД-171-ийн дагуу нисэхийн холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч байгууллага гэрчилгээжүүлсэн;
- (2) нисэхийн холбооны үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь тухайн тоног төхөөрөмжийг төлөвлөсөн хэрэглэлийн нислэгийн журамд ашиглаж болохыг бичгээр зөвшөөрсөн.

## **Е Бүлэг — Шилжилтийн зохицуулалт**

### **173.301 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт**

(a) Энэ дүрэм нь доорх бүх этгээдэд хамааралтай—

- (1) хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч;
- (2) хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ дүрэм хамаарах байгууллагад 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө—

- (1) доорх заалтуудыг мөрдөх шаардлагагүй—
  - (i) 173.51(a)(2)(iii), хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан ахлах ажилтны оронд байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан ахлах ажилтантай байвал.
  - (ii) 173.69, хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тогтоох, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд байгууллага нь 173.303-д нийцсэн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байвал:
  - (iii) 173.71(a)(1A):
  - (iv) 173.71(a)(3)(ii):
  - (v) 173.71(a)(4A); гэхдээ
- (2) 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө доорх зүйлсийг тусгасан хэрэгжилтийн төлөвлөгөөг, дагалдах ИНЕГ-ын маягыг бөглөн Даргад ирүүлнэ—
  - (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр төлөвлөсөн огноо;

- (ii) 173.69-ын шаардлагын дагуу, байгууллага нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тойм.
- (c) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц байвал, Дарга,—
  - (1) байгууллагын хэрэгжилтийн төлөвлөгөөг зөвшөөрнө;
  - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн огноог тогтооно.
- (d) Хэрэгжилтийн огноо гэдэг нь аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог Дарга хүлээн зөвшөөрсөн огноо юм.
- (e) 173.301(c)(2)-ын дагуу огноог тогтооход, Дарга доорх зүйлсийг харгалзан үзэх ёстой:
  - (1) байгууллагын чадамж;
  - (2) байгууллагын зохион байгуулалт;
  - (3) байгууллагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой эрсдэлүүд;
  - (4) гэрчилгээний хугацааг сунгах огноо;
  - (5) тухайн байгууллага эсхүл эрх бүхий байгууллага эсхүл хоёуланд нөлөөлөх аливаа нөөц эсхүл төлөвлөлт;
  - (6) хэрэгжилтийн огноо нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө байх ёстой.
- (f) Хэрэв тухайн байгууллага нь хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч бол тус гэрчилгээний өргөдөлийг, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөний хамт ирүүлэх ёстой.
- (g) Энэ дүрэм 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.

**173.303 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилтийн үеийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо**

- (a) 173.301(б)(1)(ii)-ийн шаардлагын дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог, энэ Дүрэмд заасан журмуудыг тус байгууллага нь дагаж мөрдөх болон шаардлагыг хангаж буйг бататгах зорилгоор бий болгосон байна.
- (b) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо нь дараах зүйлсийг агуулна—
  - (1) ИНД-12-ын дагуу аливаа хэрэг явдлыг мэдээлэх болон шинжлэн шалгах журмыг багтаасан аюулгүй ажиллагааны соёл болон аюулгүй ажиллагааны журмыг сайжруулахтай холбоотой бодлого;
  - (2) аюулгүй ажиллагааны үзүүлэлтүүдийг тогтоох болон ажиглах журам;
  - (3) байгууллагын тогтолцоо болон үйл явцад оршиж буй эсхүл гарч болзошгүй хүндрэлийг тодорхойлох журам;

- (4) хэрэглэлийн нислэгийн журмын бүрэн бүтэн байдалд нөлөөлж болзошгүй, байгууллага доторх эрсдэлүүдийг хянах болон бууруулах журам;
- (5) илрүүлсэн хүндрэлийг шинжлэн шалгах, задлан шинжилгээ хийх болон хүндрэлийн шалтгааныг арилгасан эсэхийг бататгах, залруулах ажиллагааны журам;
- (6) илрүүлсэн, гарч болзошгүй хүндрэлийг шалтгааныг арилгасан эсэхийг бататгах, урьдчилан сэргийлэх ажиллагааны журам;
- (7) хүсэлт гаргагч байгууллага нь өөрийн үйл ажиллагааны заавар, аюулгүй ажиллагааны бодлого болон журмуудтай нийцэж байгаа эсэхэд аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
- (8) энэ Дүрмийн шаардлагыг хангах зорилгоор, боломжтой бол аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны цаашдын нийцэл болон үр дүнтэй байдлыг бататгах статистик задлан шинжилгээ ашиглалтыг багтаасан, удирдлагын дүн шинжилгээний журам;
- (9) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг баримтжуулах, эрсдэл ба тэдгээрийг хэрхэн зохицуулах болон байгууллагын ноцтой аюулыг бүртгэх ба тэдгээрийг хянахтай холбоотой мэдээллээр хангах, аюулгүй ажиллагааны удирдлагын гарын авлага ((b)(1)-ээс (b)(8)-д шаардсан журмуудыг хамруулна).

(c) Аюулгүй ажиллагааны удирдлагын журмууд нь аюулгүй ажиллагааны бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгох, хэрэгжүүлэх мөн хадгалахыг бататгах арга хэлбэрүүдийг багтаасан байна.

(d) (b)(5)-д заасан залруулах ажиллагааны журам нь дараах зүйлсийг агуулна—

- (1) тулгарч буй хүндрэлийг хэрхэн залруулах;
- (2) уг хүндрэл нь аливаа хэрэглэлийн нислэгийн журмын бүрэн бүтэн байдалд нөлөөлсөн эсхүл нөлөөлж болзошгүйг хэрхэн тодорхойлох;
- (3) залруулах ажиллагааны үр дүнтэй байдлыг бататгах дараагийн шатны арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх;
- (4) энэ Дүрмээр шаардсан аливаа журамд залруулах ажиллагааны үр дүнгээр гарсан өөрчлөлтийг хэрхэн оруулах;
- (5) залруулах ажиллагааны үр дүнтэй байдлыг удирдлагын зүгээс хэрхэн хэмжих.

(e) (b)(6)-д заасан урьдчилан сэргийлэх ажиллагааны журам нь дараах зүйлсийг агуулна—

- (1) гарч болзошгүй хүндрэлийг хэрхэн залруулах;
- (2) тодорхойлсон болзошгүй хүндрэлийн шалтгаан өөр ямар нөлөөтэй болохыг хэрхэн тодорхойлох;
- (3) урьдчилан сэргийлэх ажиллагааг үр дүнтэй болохыг бататгах дараагийн шатны арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх;

- (4) энэ Дүрмээр шаардсан аливаа журамд урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнгээр гарсан өөрчлөлтийг хэрхэн оруулах;
- (5) урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнтэй байдлыг удирдлагын зүгээс хэрхэн хэмжих.
- (f) (b)(7)-д заасан дотоод аудитын хөтөлбөр нь—
- (1) аудитад хамрагдах үйл ажиллагааны онцлогыг харгалзан үзсэний үндсэн дээр аудитын давтамж болон байршлыг заана;
  - (2) аудитад хамрагдаж буй үйл ажиллагаанд хамааралгүй, мэргэшсэн ажилтнаар бие даалган аудитыг гүйцэтгүүлэхийг шаардана;
  - (3) аудитуудын үр дүнг аудитад хамрагдаж буй үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд болон дотоод аудитыг хариуцсан менежерт тайлагнахыг шаардана;
  - (4) өмнөх аудитаас хойш аудитад хамрагдаж буй үйл ажиллагааг хариуцсан ажилтны авсан аливаа урьдчилан сэргийлэх эсхүл залруулах ажиллагааны үр дүнг хэмжинэ;
  - (5) аудитаар хүндрэлүүд илэрсэн тохиолдолд аудитад хамрагдаж буй үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудын зүгээс урьдчилан сэргийлэх эсхүл залруулах ажиллагаа явуулахыг шаардана;
  - (6) авсан аливаа урьдчилан сэргийлэх эсхүл залруулах ажиллагааны үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийх дараагийн шатны аудит гүйцэтгэнэ.
- (g) (b)(8)-д заасан удирдлагын дүн шинжилгээний журам нь—
- (1) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны байнгын үр дүнтэй байдлын шаардлагыг тооцсоны үндсэн дээр удирдлагын дүн шинжилгээний давтамжийг заана;
  - (2) удирдлагын дүн шинжилгээ хариуцсан ахлах ажилтныг тогтооно;
  - (3) дүн шинжилгээний үр дүнг үнэлэх болон бүртгэхийг шаардана.
- (h) Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцсан ахлах ажилтан нь байгууллагын хариуцсан аливаа хэрэглэлийн нислэгийн журмын бүрэн бүтэн байдалд нөлөөлөх асуудлуудаар удирдах ажилтантай шууд харьцах эрхтэй байна.
- (i) Энэ дүрэм 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.

## **Хавсралт А — Ахлах ажилтны мэргэшил болон ажлын туршлага**

Энэ хавсралтад 173.51(а)(2)-т шаардсан ахлах ажилтан эсхүл ажилтнуудын мэргэшил болон дадлага туршлагыг тодорхойлов.

### **А.1 Хэрэглэлийн нислэгийн журмыг гэрчилгээжүүлэх ахлах ажилтан**

(a) **Сургалт** — хэрэглэлийн нислэгийн журам зохиолтын ОУИНБ-ын PANS-OPS-ын сургалт эсхүл Даргаас хүлээн зөвшөөрсөн ижил түвшний сургалтад амжилттай хамрагдсан байх.

(b) **Хэрэглэлийн нислэгийн журам ашиглалтын дадлага туршлага** — ХНД-ийн нислэгүүдэд нисэх багийн гишүүнээр оролцсон, ХНД-ийн нислэгүүдийн үйл ажиллагааг хянасан, нислэгийн хөдөлгөөний удирдлагад ажилласан зэргээр 10 жилээс багагүй хугацаанд хэрэглэлийн нислэгийн журмыг ашигласан эсхүл Даргын зүгээс хүлээн зөвшөөрсөн, эдгээртэй тэнцэхүйц дадлага туршлагатай байх.

(c) **Хэрэглэлийн нислэгийн журам зохиолтын дадлага туршлага** — 2 жилээс багагүй хугацаанд хэрэглэлийн нислэгийн журам зохиосон туршлагатай байх—

(1) Даргаас хүлээн зөвшөөрсөн мэргэшил чадвар бүхий журам зохиогчийн удирдлаганд, тухайн ажилтан гэрчилгээжүүлэхээр төлөвлөсөн төрлөөр 3-аас багагүй хэрэглэлийн нислэгийн журам зохиосон байх; эсхүл

(2) хэрэглэлийн нислэгийн журмын өөр төрлийг гэрчилгээжүүлэх тохиолдолд Даргаас хүлээн зөвшөөрсөн ойролцоо төрлийн хэрэглэлийн нислэгийн журмыг зохиосон эсхүл гэрчилгээжүүлсэн байх.

## **А.2 Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хариуцах ахлах ажилтан**

173.51(a)(2)(iii)-т заасан ахлах ажилтан эсхүл ажилтнууд нь гэрчилгээ эзэмшигч байгууллагын үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны тогтолцооны удирдлагатай холбоотой ур чадвар болон дадлага туршлагатай байна.